Алс Дорнодын нэгдүгээр хэлтсийн дарга М.С.Капицагийн мэдээллийн үндсийг сийрүүлбэл:

Итгэлцлийн арга хэмжээ тогтоохыг, сонирхвол Европын туршлагын үндсэн дээр зөвлөлдөн санал солилцоход бэлэн байна гэдгээ бид элчин сайд нараараа дамжуулан хятад, японы талд мэдэгдсэн боловч тэд татгалзаад байна.Европын туршлага гэдэг нь Хельсинкид тохирсоны адил цэргийн сүргууль хийхэд харилцан ажиглагч урих, цэргийн хөдөлгөөний талаар харилцан мэдээлэх зэрэг арга хэмжээ юм.Түүн дээр усан цэрэг, агаарын хүчний хөдөлгөөний талаар харилцан мэдээлэх тухай нэмж санал болгосон.

Япончууд бидний эсрэг юуны өмнө "хойд нутгийн асуудал" гэгчээ сөргүүлж байна.АНУ Алс Дорнодод цэрэг зэвсгээ байлгах сонирхолтой учраас япончууд тэдний байр суурийг аялдан дагаж байгаа юм.

Бид саяхан элчин сайдынхаа зочноор Хятадад очоод ирлээ. Хятадын ГЯЙ-ны хүмүүстэй уулзаж ихэвчлэн улс төрийн асуудлаар ярьсан бөгөөд үүний дотор итгэлцлийн арга хэмжээний тухай дахин сануулж тайлбарлав.Афганистан,Монголоос зөвлөлтийн цэргийг гаргаагүй цагт ийм арга хэмжээ тогтоох талаар ярилцаж чадахгүй гэж тэд ярьж байна.

Үнэнийг хэлэхэд итгэлцлийн арга хэмжээний тухай санал бол гол нь Япон, Хятад хоёрт чиглэсэн цэвэр улс төрийн лоозон юм.Уг үзэл санааг бид одоогоор зөвхөн "улс төрийн агаар " болгон ашиглаж байх зорилготой.Хэрэв хилийн асуудлаарх хэлэлцээ дахин сэргэвэл итгэлцлийн арга хэмжээний тухай нэг зүйлийг баримт бичигт оруулах санал тавихаар төлөвлөж байна.

Энэ дашрамд мэдээлэхэд: ЮНЕСКО-гийн шугамаар туурвиж байгаа Төв Азийн түүхээс хятад мэргэжилтнүүдийн бичих сэдэвт Хятадын газар нутгийн санаархлыг зөвтгөх, түүхийг гуйвуулах гэсэн оролдлого илэрхий байна.Иймд энэ оролдлогыг шийдвэртэй

нлцаах, болохгүй бол түүхийг үнэн зөвөөр тусгахыг шаардан аль болохоор хойш татах, эсвэл энэ ажлыг бүхэлд нь нураах чиглэлийг бид мэргэжилтнүүддээ өгөх гэж байна.Энэ түүхийг бичихэд оролцож байгаа манай монгол нөхөд ч мөн ингэж ажиллавал сайн байна.

Зөвлөлт-хятадын харилцааны хувьд гэвэл хятадууд ЗХУ-тай харилцаагаа сайжруулахыг хүсэхгүй байна.Тэд бэлэн бус, тийм төлөвлөгөө ч алга байна.Гэхдээ байдлыг хурцатгахгүй, ёс төдий жижиг алхмуудаар хязгаарлах бодлоготой.Тэд өнгөн дээрээ идэвх гаргасан дүр үзүүлэхэд үнэн хэрэгтээ тодорхой, хоёр талын харилцаанд ашиг тус болохуйц юм хийхгүй байна.

Бид шинжлэх ухаан-техникийн харилцаа сэргээх, биеийн тамир, спорт, оюутны солилцоо хийх санал тавьсан.Хятадууд судалж байна гэсэн.Бид ч нэг их найдлага тавихгүй байна.Оюутан солилцдог юм гэхэд 10-10-аас хэтрэхгүй, зохих хяналтад байх юм.

Бид ЗХУ-д оршин суугч хятад иргэдийг хатуу барьж байдаг. Москвад 1700 орчим хуацяо бий.Тэднийг ЭСЯ-ны нь оруулдаггүй, хэрэг зорилгыг нь тодорхойлж байж тусгай зөвшөөрөл олгодог. Харилцан адил байх зарчмын үндсэн дээр хятадын дипломатуудыг төв Азийн бүгд найрамдах улсууд, Казахстанд очихыг хориглосон.

Хоёр талын худалдаа 1981 онд 141 сая рубль болж, 1982 онд 230 сараар тохирсон боловч энэ хэмжээнд хүрэхгүй байх гэж бодож байна.Хятадууд социалист бусад оронтой худалдаагаа өсгөх санал тавьдаг боловч үүнийгээ хэрэгжүүлэхгүй байна.Өнгөрсөн онд Югославын, Румын найз нартайгаа хүртэл худалдааныхаа хэмжээг 2 дахин бууруулсан нь "ялгавартай хандах бодлогын" мөн чанарыг харуулж байна.

Та нар Хятадтай худалдаагаа хөгжүүлж болно.Бид ачаа бараанхаа нэг хэсгийг танай руу чиглүүлж, танай нутгаар гардаг транзит тээврийн хэмжээг өсгөхөд туслахыг хичээж байна.

Хил орчмын худалдаа хийвэл сайн хяналт тавих нь зүйтэй.Иймд худалдааг хэт үнэлэх хэрэггүй юм.Бид ч мөн хэдэн жилийн омно ийм санал тавьж байсан, одоо тодорхой үр дүн алга.

Өөр чиглэлээр харилцаа сэргээхэд арай эрт болов уу гэж бодож байна.Хятадууд ч өөрсдөө социалист орнуудтай харилцаагаа мэдэгдэхүйц сайжруулах, империализмыг айлгахуйц юм хийхгүй байх.

Хятадын дотоод байдал арай тогтвортой болсон боловч улс төрийн дотоод тэмцэл үргэлжилж байна.Дэн-н групп бэхжсэн, гэхдэ бүрэн ялж чадаагүй байна.Хятадууд эдийн засгийн асуудалд анхаар болсон нь зүйтэй, бидний хүсэж байсан хэрэг юм.Үүний дүнд технократууд олширно.Тэд чинь улс төрийн чалчаанд дургүй улс шүү дээ

Одоогоор хятадын хөгжлийн хурдац доогуур, 4-5 хувь байна. Тээвэр холбоо, эрчим хүч гэвэл инфраструктурын асуудал маш түвэгтэй, инженер-техникийн ажилтнууд их дутагдаж байна.2000 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд нь мэргэжилтэй ажилчид асар ихээр дутагдах юм.Тэр үед байдал нэг их өөрчлөгдөхгүй, 70-аад оны үеийн америкийн үйлдвэрлэлийн 80 орчим хувийг гаргах хэмжээнд хүрнэ гэж бодож байна.

Одоо Хятадад социализмын ул суурийг уусган идэх процесс явагдаж байна.Эдийн засгийн хуучин хоёр сектор дээр төрийн монопольт, капиталист хоёр сектор нэмэгдлээ."Баяжигтун" гэсэн урна дэвшиж, хүн бүгд худалдаа наймаа руу зүтгэх болов.10 жилийн дараа гэхэд хөрөнгөтнүүд, нударган баячууд олширч танкаар нухчих дарахаас өөр аргагүй болно.Социализмын эсрэг аргаар, зөвлөлтийн эсрэг үзлээр! социализмыг байгуулах гэж оролдож байгаа нь гүн эмгэнэлтэй хэрэг юм.

Хятадын гадаад бодлогын хувьд бол тэрээр империалистуудын бага түншийн үүргээ бүрэн гүйцэтгэж байна.Социалист орнуудтай

харилцаагаа тасалсан нь санамсаргүй хэрэг биш ээ. Мао, Чжоу нар анхнаасаа л Хятадыг шинэчлэх хөшүүрэг гэж АНУ-ыг үзэж байсан юм.

Хятад, АНУ-ын хооронд ноцтой зөрчил бий. Хятад АНУ-ыг зөвлөлтийн эсрэг түлхэж, АНУ өөрийг нь түлхэж байна. Бид америкчуудтай уулзахдаа хятадуудын сэтгэлгээний онцлогийг зааж, бүхэл бүтэн лекц унших даг. Хятадууд хэнтэй ч удаанаар нөхөрлөдөггүй гэдгийг хэлдэг.

Магадгүй 10-15 жилийн дараа хятадуудын нүд онгойж, АНУ, ЗХУ-аас адил тэгш зай барих болж магадгүй. Тэр цагт зөвлөлтийн эсрэг үзэл нь саарч, хоёр орны харилцаанд хурцадмал байдал наймжиж болох юм. Одоогоор зөвлөлтийн эсрэг үзлээсээ болж алдана гэж айх юм Хятадад алга. Энэ үзлээрээ өрнөдөөс хөрөнгө мөнгө наймаалж авах нь түүнд илүү ашигтай бөгөөд тийм ч учраас Тайванд зэрэг зарим асуудлыг үл хайхран АНУ, Баруун Европын орнуудтай харилцаагаа бүхий л талаар өргөжүүлж байна.

Японы улс харилцахад тун бэрх түнш болж байна. Эдийн засгийн өндөр хөгжилдөө түшиглэн олон улсын тавцан дээр улс төрийн томоохон гүрэн болохыг хичээж байна.

Япончуудыг "зөвлөлтийн аюул" гэж шуугиж "газар нутгийн асуудал" гэгчийг санаатайгаар дэвэргэн, ЗХУ-ын эсрэг хориг арга хэмжээ авахыг дэмжиж, соёлын солилцоог багасгаж байна. Европ тив, польшийн хэрэгт оролцож, "хэрэв ЗХУ Азид алдаа хийхгүйг хүсвэл Япон туслахад бэлэн" гэж империалист хэлээр ярих болов. Курилын арлуудыг Японд буцаах өгнө гэвэл Номхон далайд гарцгүй болно гэсэн үг.

Одоогоор хоёр талын эдийн засгийн харилцаа идэвхтэй хэвээр байна. Алс Дорнодод бид япончуудтай эдийн засгийн томоохон хоёр проект хэрэгжүүлж, японы зээлээр 3 үйлдвэр барьж байна.

3 сая тн мод Японд худалддаг.Нефть, хийн хайгуулын ажлыг японы зээлээр хөрөнгөжүүлэх асуудал бий.Японтой компенсацын журмаар үйлдвэр байгуулж буй.Харин японы мэргэжилтэнг оруулахгүй байгаа Хоёр жилийн дараа БАМ ашиглалтад орж японы ачаа барааг өрнөд рүү зөөвөл БАМ-ыг барихад зарсан зардлаа /20 милliард рублийг/ бид 3 жилд нөхөж чадна.

БНАСАУ-тай манай харилцаа хэвийн боловч чин сэтгэлийн биш, тодорхой нэгэн температурт байна.Бид Солонгост 15 объект барьж байгаа, цэргийн объект байхгүй.Олон улсын асуудлаар солонгос нөхөд биднийг "хөнжил дороо" дэмжиж байдаг.Бид тэдний конфедерацын асуудлыг ил дэмжихгүй байна.ЭҮНХ-ий хүрээн дахь солонгосын үйл ажиллагаа олигтгүй бөгөөд олон улсын байдал хурцадсан нь хоёр хэт их гүрний буруу гэж мэтээр ярьж баруун жигүүртэй нь нийлж явна.

Солонгосын дипломатуудаас манай зарим объектыг /пуужингийн хатуу шатахуун зэрэг/ тагнаж яваад газар дээрээ баригдсан тохиолдол бий.

Бид Өмнөд Солонгосын төлөөлөгчдийг олон улсын байгууллагын шугамаар болж буй арга хэмжээнд оруулдаг.Солонгос нөхөд эсэргүүцэл илэрхийлдэг боловч аажмаар "дасч" байна.Манай улс 1988 онд Өмнөд Солонгост болох олимпийн тоглолтод оролцох болно.Тэдний төлөөлөгчидтэй уулзахаас зайлсхийхгүй байх зааврыг бид гадаадад суугаа хүмүүстээ өгөөд байна.Мөн НҮБ-ын шугамаар өөрийн "түшмэдүүдийг" Өмнөд Солонгост явуулж буй.

Одоогоор бид Өмнөд Солонгостой худалдааны харилцаагүй, гэхдээ цаашид гуравдагч орны нүүсээр дамжуулан худалдаа хийхийг үгүйсгэж болохгүй юм.

Вьетнамчууд бидэнд чин сэтгэлээсээ хандаж байна гэж хэлж болно.Тэдний эдийн засгийн байдал хүнд байна.Тийм ч учраас

Вьетнам нөхөд сүүлийн хэлэхдээ "15 жил та нараар даалгая, дараа нь эдийн засгийн бүхэл район гаргаж ЗХУ-тай тооцоо хийнэ" гэж байгаа юм.

Кампучи бие дааж чадахгүй хэвээр цагт вьетнамчууд тэндээс гарахгүй.Хятадууд пол-потынхныг ашиглаж "сунжраа дайныг" тулгаж байна.Тайландад одоо 40000 орчим полпотчууд байгаа бөгөөд Тайланд тэднийг яахаа мэдэхгүй, Кампучийн эсрэг тухирч хороох тактик баримталж байна.Тайландын хөрөнгөтнүүд удаа дараагийн дайнаас ихэд баяжсан тул одоо засгийн эрхийг авах ноцтой санаархал өвөрлөж, үүнээс айж сүрдсэн феодал бүлгийнхэн Хятадын тоглоом болж байна.

Энэтхэг Пакистантай дайтах гэж байна.Гэрээр нэн удахгүй урьдчилан сэргийлэх цохилт хийж Пакистаныг гурав-дөрвөн хэсэгт хуваан ашуулгүй болгох санаатай юм.Мөн өөрөөдөд Хятад ямар байр суурьтай байхыг тодруулах, "гарыг нь уях" зорилгоор тэд холбоо барихаар эрэлхийлж байна.Мөн Энэтхэгт зэвсэг нийлүүлж байна.

Энэтхэгийн хөрөнгөтнүүд ЗХУ-тай хамтарч ажиллахын чухлыг ойлгож байгаа боловч "коммунистууд Афганистанд ирчихлээ" хэмээн сүрдэж АНУ-ыг зовлөлтийн эсрэг тэнцвэр болгохыг хүсч байна.Гэхдээ америкчууд их мулгуу бодлого явуулж байгаа учраас Франц руу нэг хандлаа.Гэтэл Франц нь хүч чадлаар оул, "Мираж" нийлүүлэхээс цаашлахгүй байна.

Афганистаны байдал наашгай болж байна.Гэхдээ бэрхшээл их бий.Армы байгуулах гэхээр тарж зугтаад байх юм.Одоо арай гэж 100-120 мянган хүнтэй боллоо.Хилийг хяналтдаа авсан боловч газар нутгийн 70 хувьд нь хол хоромтой.Хижиг отрядуудыг оролцсон басмачийн дайн болж байна.

Санваартнуудын талаар гаргасан нугалаа зогсож, сэхээтний нэг хэсгийг улсын албанд авч, боловсон хүчин хурдан ахих боллоо.

Удахгүй Афганистан, Пакистаны ГҮЙ-дын хооронд хийх болсон уулзалт амжилттай болж арай чадахгүй байх гэж үзэж байна, гэж ярив.

Уулзалт 6 дугаар сарын 9-ний 10^{00} цагаас 12^{00} хүртэл үргэлжилж зөвлөлтийн талаас нөхөр А.П.Катеринич, М.И.Басманов, А.Кондратенко, монголын талаас элчин сайд Д.Готов болон О.Дамдин-дорж, Х.Бэхбат нар байв.

ТАНИЛЦСАН
НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ САЙД Д.ЙӨНДОН /

Тэмдэглэсэн / Х.Бэхбат /